

ИХ намын Улс төрийн зөвлөлийн
2020 оны 06-р сарын 22-ны өдрийн
хурлаар батлав.

**ИХ НАМЫН АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2030”
ЭРХЭМ ЗОРИЛГО**

1. Орон нутгийн бүтээн байгуулалтыг иргэдийн оролцоотойгоор өрнүүлж 2030 онд бүс нутагтаа тэргүүлэгч, 2044 онд эх дэлхийдээ тэргүүлэгч улс үндэстэн болох.
2. Монгол Улсын иргэнд тулгамдсан асуудал бол аймаг, нийслэл, сум, дүүргийн тулгамдсан асуудал гэсэн гол зарчмыг мөрдлөг болгож, оновчтой хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлэх замаар, үргүй зардлыг бууруулна.
3. Шударга, хөгжингүй улс болгох гол хүч болсон Монгол хүнийг үндэсний үнэт зүйлтэй, эв нэгдэлтэй, бие биенээ харилцан дэмжин хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн иргэнд суурилсан эрүүл тогтолцоог бий болгоно.
4. Ил тод, нээлттэй, эрх чөлөөтэй, ардчилсан, хариуцлагатай, иргэддээ бүрэн эрхийн бололцоог олгосон, бүх бүх шатанд ил тод нээлттэй тогтолцоог бий болгоно.
5. Орон нутгийн хөгжилд Хөдөө аж ахуй, Аялал жуулчлалын салбарыг чухалчлан авч үзэж суурь эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.
6. Орон нутгийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд нөлөөлөх, оролцох иргэдийн идэвхтэй, зерэг хандлагатай оролцоог нэмэгдүүлнэ.
7. Үндэсний өнгө төрхтэй иргэндээ ээлтэй, аюулгүй сууринг иргэдийн дэмжлэгийн байгуулна.

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2030”
БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

Энэхүү мөрийг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах суурь зарчмыг баримтална.

- Аливаа залгамж халаатай, үүслийг үргэлжлүүлэх бүтээлч санаачилга бол хөгжлийн үндэс гэж үзнэ.
- Нэг иргэн нэг амьдрал гэсэн суурь зарчмыг мөрдлөг болгож, хүн бүрийг гэр бүл, хамт олонд нь хариуцуулж, “Бусдын алдаа надаас болдог, хохирол нь намайг хорлодог” зарчмыг дээдэлнэ.
- Өвөг дээдсийн өвлүүлсэн зан заншиг, ёс суртахууны амин мөн чанарыг нандигнан хадгалж, төр ёсны зарчмыг түгээн дэлгэрүүлнэ.
- Салбарын суурь шинжтэй өөрчлөлтийг мэргэжлийн, салбарынхны үзэл бодолд суурилж хэрэгжүүлнэ.
- “Мууг устгахаас дутууг нь нөхсөн нь дээр. Аливаа юм муудсан шалтгаан нь дутагдсан юм уу илүүдсэнд оршино. Дутагдсаныг нь нөхөөд илүүдсэний тэгшилбэл тэр юм угтаа сайн зүйл болдог” зарчмыг мөрдөж харилцааны хурдыг бий болгоно.



УЛДАНБААТАР ХОТ

MPM MOVEMENT PARTY

ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НА

ТТН 3716 ү 8489041

8217143139
ДЮА0066-и-18201

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2030”
ТЭРГҮҮЛЭХ 13 ЗОРИЛТ**

1. Улс төрийн намын гишүүнчлэлээс болж, ард иргэд талцан хуваагдаж иргэдийн нийтлэг эрх ашиг хохирдог явдлыг үндэсний үнэт зүйл дээр тулгуурласан улс төрийн харилцаанд шилжүүлж арилгана.
2. Орон нутагт тулгамdsan асуудлыг үндэсний хэмжээний цогц, оновчтой хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлэх замаар бууруулна.
3. Төрийн бус байгууллагуудыг сонгодог иргэний нийгмийн байгууллагын зарчмаар ажиллах бие даасан тогтолцоог бий болгоно.
4. Хүүхэд, залуучууд, ахмадуудыг нийгэм, байгаль зүйн шаардлага онцлогт нийцсэн бодлогоор хөгжүүлж, бүтээн байгуулалтад оролцуулна.
5. НҮБ-н Тогтвортой хөгжлийн зорилт, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын холбогдох хууль, бодлого, зорилтын хүрээнд байгаль орчинд ээлтэй эрүүл орчныг орон нутагт бүтээн байгуулна.
6. Нийгэм, Дэд бүтэц, Хөдөө аж ахуй, Аялал жуулчлалын салбарт их бүтээн байгуулалтыг өрнүүлж, Монгол ажиллах хүчнийг сургах, дадлагажуулах системийг бий болгоно.
7. Хот суурингийн хөгжлийн бодлогыг иргэдийн хурлын танхимаар хязгаарладаг явдлыг эцэс болгож, иргэдээр хэлэлциүүлж хэрэгжүүлдэг болно.
8. Үндэсний үйлдвэрлэлийг гадаадын зах зээлд гаргах төрийн болон үндэсний маркетингийн цогц бодлогыг иргэд аж ахуйн нэгжийн хүчээр хэрэгжүүлэх.
9. Тэргүүлэх салбаруудад бүтээлч, инновацид сууриссан санал нэвтрүүлэхэд учрах хүнд суртлыг хална. Хот, суурингийн хөгжилд иргэдийн санаачлага нэвтрүүлэх, иргэдийн хүчээр хотын соёлыг дээшлүүлнэ.
10. Төрөөс олгох тусгай зөвшөөрлийг туршлагад сууриссан давуу байдлаас шинэ санаачилга, шинэ технологийг нэвтрүүлэхэд сууриссан өрсөлдөөнт тогтолцоонд шилжүүлнэ.
11. Иргэнд тулгарч буй бэрхшээлийг дан ганц төрийн байгууллагаар шийдүүлэх тогтолцоог халж, нийгмийн хариуцлагын шинэ хандлага, тогтолцоог хөгжүүлнэ.
12. Төрийн үйлчилгээг шинэ арга барилд шилжүүлнэ. Төрийн өндөр алба тушаалтнуудыг хөрөнгө орлогын мэдүүлгийг бүх иргэдэд хянуулах тогтолцоог бий болгоно.
13. Хөдөө аж ахуй, Аялал жуулчлалын салбарыг орон нутгийн ард иргэдийн оролцоотойгоор аж ахуй, бараа түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түвшинд олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх суурь бүтцийг бүтээн байгуулна.



УДААНЫГАТАР ХОТ
07/08/2018 04:11
ТӨГГОЛЦООНД
тогтолцоонд

